



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/158/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Утас: 99862066 Цахим хаяг: peakomaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СА 2022/158-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ З.ЭНХЦОЛМОН
ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхон туул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Орхон туул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,413,125.23	20,049,428.23
33	АВЛАГА	358,112.93	626,303.93
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	268,191.00
33500	Бусад авлага	358,112.93	358,112.93
33510	Байгууллагаас авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	16,055,012.30	19,423,124.30
35400	Хангамжийн материал	16,055,012.30	19,423,124.30
35410	Бичиг хэргийн материал	197,940.80	197,940.80
35420	Аж ахуйн материал	15,510,333.50	14,343,999.50
35460	Хүнсний материал	346,738.00	4,264,984.00
35470	Бусад хангамжийн материал	-	616,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	248,433,564.12	237,097,856.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	248,433,564.12	237,097,856.49
39200	Биет хөрөнгө	233,835,564.12	222,749,856.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	(20,285,828.47)	(29,650,837.51)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	16,140,376.00	20,740,276.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,849,153.55)	(8,982,833.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,243,987.88	22,243,987.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,705,850.63)	(13,625,319.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,141,233.40	6,141,233.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,234,305.51)	(3,501,754.95)
39300	Биет бус хөрөнгө	14,598,000.00	14,348,000.04
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(249,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,348,000.00	13,348,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	264,846,689.35	257,147,284.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,316.00	609,694.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,316.00	609,694.00
41300	Өглөг	2,316.00	609,694.00
41360	Бусад өглөг	2,316.00	609,694.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,316.00	609,694.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	264,844,373.35	256,537,590.72
51	Засгийн газрын хувь оролцоо	264,844,373.35	256,537,590.72
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,475,639.00	90,475,639.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(32,145,805.00)	(40,452,587.63)
51210	Өмнөх үеийн үр дүн	(34,815,130.78)	(32,145,805.00)
51220	Тайлант үеийн үр дүн	2,669,325.78	(8,306,782.63)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	206,514,539.35	206,514,539.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	264,846,689.35	257,147,284.72

2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	425,330,225.90	325,861,527.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,248,500.00	278,646.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,248,500.00	278,646.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,248,500.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	278,646.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,081,725.90	325,582,881.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	390,834,800.00	303,464,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	390,834,800.00	303,464,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	128,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	128,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,246,925.90	21,990,181.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,246,925.90	21,990,181.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	422,660,900.12	334,168,309.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,660,900.12	334,168,309.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	323,600,712.45	320,424,525.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,790,364.00	235,280,555.00
210101	Үндсэн цалин	173,426,207.00	173,329,715.00
210102	Нэмэгдэл	40,785,999.00	41,040,131.00
210104	Урамшуулал	20,578,158.00	20,910,709.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,329,251.57	30,708,897.51
210201	Тэтгэврийн даатгал	19,985,688.57	21,172,638.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,335,892.00	2,480,831.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,868,712.00	1,881,455.00
210204	Ажилгүйдлийн даатгал	467,176.00	470,364.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,671,783.00	4,703,609.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,958,621.90	21,990,181.00
210301	Гэрэл, цахилгаан	2,475,361.90	2,160,576.00
210302	Түлш, халаалт	21,229,260.00	18,575,605.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,033,100.00	2,273,200.00
210401	Бичиг хэрэг	97,200.00	91,800.00
210402	Тээвэр, шатахуун	661,500.00	514,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,700.00	910,300.00
210404	Ном, хэвлэл	70,700.00	66,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	483,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,025,000.00	206,000.00
2105	Нормативт зардал	13,919,588.00	11,510,084.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,000.00	142,700.00
210502	Хоол, хүнс	13,205,288.00	10,006,504.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	652,300.00	1,360,880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	472,000.00	446,600.00
210604	Урсгал засвар	472,000.00	446,600.00
2107	Томилолт, зочны зардал	87,200.00	93,800.00
210702	Дотоод албан томилолт	87,200.00	93,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	373,500.00	836,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	373,500.00	350,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	486,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,637,086.98	17,285,207.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	955,900.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,450,000.00	1,349,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,231,186.98	15,935,607.63

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,060,187.67	13,743,784.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,060,187.67	13,743,784.49
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,060,187.67	13,743,784.49
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,669,325.78	(8,306,782.63)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,669,325.78	(8,306,782.63)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	420,081,725.90	325,582,881.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,081,725.90	325,582,881.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	390,834,800.00	303,464,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	390,834,800.00	303,464,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	128,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	128,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,246,925.90	21,990,181.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,246,925.90	21,990,181.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	412,081,725.90	320,982,981.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,081,725.90	320,982,981.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,021,538.23	307,239,196.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,708,028.33	234,974,754.00
210101	Үндсэн цалин	171,749,607.00	173,234,115.00
210102	Нэмэгдэл	41,637,296.33	41,040,131.00
210104	Урамшуулал	20,321,125.00	20,700,508.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,198,644.00	30,579,911.51
210201	Тэтгэврийн даатгал	19,855,081.00	21,172,638.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,335,892.00	2,351,818.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,868,712.00	1,881,455.00
210204	Ажилгүйдлийн даатгал	467,176.00	470,364.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,671,783.00	4,703,636.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,246,925.90	21,990,181.00
210301	Гэрэл, цахилгаан	2,814,866.90	2,160,576.00
210302	Түлш, халаалт	25,178,059.00	18,575,605.00
210303	Цэвэр, бохир ус	1,254,000.00	1,254,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,183,100.00	2,273,200.00
210401	Бичиг хэрэг	97,200.00	91,800.00
210402	Тээвэр, шатахуун	661,500.00	514,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,700.00	910,300.00
210404	Ном, хэвлэл	70,700.00	66,800.00

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	524,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,175,000.00	165,300.00
2105	Нормативт зардал	14,346,240.00	14,695,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,000.00	58,600.00
210502	Хоол, хүнс	13,631,940.00	14,020,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	652,300.00	616,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	472,000.00	446,600.00
210604	Урсгал засвар	472,000.00	446,600.00
2107	Томилолт, зочны зардал	87,200.00	93,800.00
210702	Дотоод албан томилолт	87,200.00	93,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	373,500.00	836,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	373,500.00	350,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	486,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,405,900.00	1,349,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	955,900.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,450,000.00	1,349,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,060,187.67	13,743,784.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,060,187.67	13,743,784.49
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,060,187.67	13,743,784.49
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,000,000.00	4,599,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,000,000.00	4,599,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,000,000.00	4,599,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,000,000.00	4,599,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,000,000.00	4,599,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,000,000.00)	(4,599,900.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн
1	2019 оны 12-р сарын 31-	90,475,639.00	206,514,539.35	(34,815,130.78)

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	н э э р х ү л д э г д э л			
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(34,815,130.78)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үрдүн	-	-	2,669,325.78
10	2020 оны 12-р сарын 31- нээ рх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(32,145,805.00)
11	2021 оны 1-р сарын 1- нээ рх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(32,145,805.00)
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(32,145,805.00)
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн нүрдүн	-	-	(8,306,782.63)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(40,452,587.63)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	331,871,900.00	311,711,096.51	20,160,803.49	93.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,871,900.00	311,711,096.51	20,160,803.49	93.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,871,900.00	311,711,096.51	20,160,803.49	93.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,491,400.00	234,974,754.00	6,516,646.00	97.30
210101	Үндсэн цалин	172,764,400.00	173,234,115.00	(469,715.00)	100.27
210102	Нэмэгдэл	49,524,900.00	41,040,131.00	8,484,769.00	82.87
210104	Урамшуулал	19,202,100.00	20,700,508.00	(1,498,408.00)	107.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,385,200.00	30,579,911.51	2,805,288.49	91.60
210201	Тэтгэврийн даатгал	23,125,600.00	21,172,638.00	1,952,962.00	91.55
210202	Тэтгэмжийн даатгал	2,564,900.00	2,351,818.00	213,082.00	91.69

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,051,900.00	1,881,455.00	170,445.00	91.69
210204	Ажилгүйдлийн даатгал	513,000.00	470,364.00	42,636.00	91.69
210205	Эрүүл мэндийн даатгал	5,129,800.00	4,703,636.51	426,163.49	91.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,884,300.00	21,990,181.00	5,894,119.00	78.86
210301	Гэрэл, цахилгаан	4,906,800.00	2,160,576.00	2,746,224.00	44.03
210302	Түлш, халаалт	21,230,400.00	18,575,605.00	2,654,795.00	87.50
210303	Цэвэр, бохир ус	1,747,100.00	1,254,000.00	493,100.00	71.78
2104	Хангамж, бараа материалын зардал	2,145,200.00	2,145,200.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	91,800.00	91,800.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	514,500.00	514,500.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	899,400.00	910,300.00	(10,900.00)	101.21
210404	Ном, хэвлэл	66,800.00	66,800.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	407,400.00	396,500.00	10,900.00	97.32
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	165,300.00	165,300.00	-	100.00
2105	Нормативт зардал	18,627,800.00	14,695,150.00	3,932,650.00	78.89
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,600.00	58,600.00	-	100.00
210502	Хоол, хүнс	17,953,000.00	14,020,350.00	3,932,650.00	78.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	616,200.00	616,200.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,569,500.00	5,046,500.00	523,000.00	90.61
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,600,000.00	4,599,900.00	100.00	100.00
210604	Урсгал засвар	969,500.00	446,600.00	522,900.00	46.06
2107	Томилолт, зочны зардал	93,800.00	93,800.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	93,800.00	93,800.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,325,100.00	836,000.00	489,100.00	63.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	353,100.00	350,000.00	3,100.00	99.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	486,000.00	486,000.00	50.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,349,600.00	1,349,600.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,349,600.00	1,349,600.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	331,871,900.00	311,711,096.51	20,160,803.49	93.93
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	303,464,700.00	289,720,915.51	13,743,784.49	95.47
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303,464,700.00	289,720,915.51	13,743,784.49	95.47
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,407,200.00	21,990,181.00	6,417,019.00	77.41
320001	Орон нутгийн төсвөөс	28,407,200.00	21,990,181.00	6,417,019.00	77.41
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	113,049.00	162.00	112,887.00	0.14
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	-	100.00

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	113,000.00	113.00	112,887.00	0.10
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	113,000.00	113.00	112,887.00	0.10
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	113,000.00	113.00	112,887.00	0.10
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	24.00	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч	24.00	24.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	128,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	128,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	128,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	128,000.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00
210406	Хог хаягдал, хортон шавьж	0.00	128,000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хунс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	0.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	128,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	128,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	128,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	0.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэг/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн шилэн данс, анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ны аудитор А.Батболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэг нь “ Бага насны хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад багш, цэцэрлэг, эцэг эх, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангаж ажиллая” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны гол чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны боловсрол олгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл. Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 422,660.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,339.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 4,437.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон туул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,699.4 мянган төгрөгөөр

буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	358.10	626.30	268.20
Бараа материал	16,055.00	19,423.10	3,368.10
Үндсэн хөрөнгө	248,433.50	237,097.80	(11,335.70)
Нийт хөрөнгө	264,846.60	257,147.20	(7,699.40)
Өр төлбөр	2.30	609.70	607.40
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	264,844.30	256,537.50	(8,306.80)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	264,846.60	257,147.20	(7,699.40)

Тайлант онд цалингаас суутган тооцох ХХОАТ-ын тооцооллыг хянаагүйгээс илүү шилжүүлэн 268.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19,423.1 мянган төгрөг болж 3,368.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 17,354.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас нийт 278.6 мянган төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 14,264.5 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 293,108.6 мянган төгрөг болж өмнөх оноос 4,599.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 256,537.5 мянган төгрөг болж 8,306.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 325,861.5 мянган төгрөг болж өмнөх оноос 99,468.7 мянган төгрөгөөр буюу 23.4 хувиар буурсан байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого 87,370.2 мянга, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 7,256.7 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 334,168.3 мянган төгрөг болж өмнөх оноос 88,492.6 мянган төгрөгөөр буюу 21 хувиар буурсан нь Ковид-19 цар тахлын улмаас цалин, нийгмийн даатгал, тогтмол зардал, хоол, эд хогшил, урсгал засварын зардал зэрэг зардлууд хэмнэгдсэн, мөн үндсэн хөрөнгийн элэгдэл, төвлөрүүлэх шилжүүлгийн зардлууд голлон нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 434,480.9 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 102,609.0 мянган төгрөгөөр бууруулж, **331,871.9** мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 331,871.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 303,464.7 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 28,407.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 303,464.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 21,990.2 мянган төгрөг, нийт 325,454.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **311,711.1** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 13,743.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 311,711.1 мянган төгрөг буюу 93.9 хувьтай тайлагнагдсан нь цалин урамшууллын зардлыг 6,516.6 мянган төгрөгөөр, норматив зардлыг 3,932.7 мянган төгрөгөөр, тогтмол зардал 5,894.2 мянган төгрөгөөр зардлуудыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгалын санхүүжилтэд 128.0 мянган төгрөг олгосныг Мөнх Ариун Сэлэнгэ ХХК-аар ариутгал хийлгэж зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур*

чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 126 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож, 10 мэдээллийн огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Орхон туул сумын 1 дүгээр цэцэрлэгт 331,871.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 311,711.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.1 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Орхон туул сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 958.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 174.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	958.3	2	958.3	100
Албан шаардлага	1	174.5	1	174.5	100
Нийт дүн	3	1,132.8	3	1,132.8	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 37,082.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7,762.6 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1,842.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэн, 27,477.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд тухайн оны батлагдсан төлөвлөгөөг 6,417.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан.
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүнгийн тайлан 1,250.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.
- 95.6 мянган төгрөгийн зардлын ангилал буруу бүртгэснийг тус тус аудитын явцад залруулав.

4.2 Албан шаардлага

1. Эрхлэгч З.Энхцолмонд сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/46 дугаар захирамжаар 964.9 мянган төгрөгийн урамшууллыг улирлын

ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх *“Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 4.6. *“Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно”* гэсэн заалтыг зөрчсөн ба *“Үнэн зөв байдал”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөрийн тооцоог хянан баталгаажуулаагүйгээс ХХОАТ-ын 268.2 мянган төгрөгийн авлага, сумын ойн хандивт олгохоор суутгасан боловч шилжүүлээгүйгээс 609.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлээ.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 27,477.2 мянган төгрөгийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”* гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу*

бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож, 10 мэдээлэл мэдээлээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.2, 6.3 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэг	7	37,082.6	3	7,762.9			2	1,842.8	2	27,477.2

